

Тайлан /2015 он/

1. *Төлөвлөгөө*: НМХГ-ын Ёс зүйн хороо нь ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлын төлөвлөгөөг 2015 оны 01 дүгээр сарын 28-нд боловсруулан баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

НМХГ-ын Ёс зүйн хорооны хурлын дэг, ёс зүйн хорооны ажиллах журмыг шинээр боловсруулж батлуулсан. Байгууллагын ажлыг үнэлэхэд ажилтнуудын гаргасан ёс зүйн зөрчлийг нэг шалгуур үзүүлэлт болгон тусгахаар байгууллагын Дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

2. *Сургалт*: Албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд сургалтууд зохион байгуулсан. Үүнд:

2.1. НМХГ-ын мэдээллийн цагаар АТГ-ын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлигаас ангид ёс зүйтэй хяналт” сургалт зохион байгуулсан.

2.2. 2015.11.03-нд “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр Экспорт импортын хяналтын хэлтсийн нийт улсын /ахлах/ байцаагчдад сургалт зохион байгуулсан.

2.3. 2015 оны 11 – 12 сард чиглэлийн 3 хэлтэст, тухайлбал Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтэс, Дэд бүтцийн хяналтын хэлтэс, Эрүүл мэнд боловсрол соёлын хяналтын хэлтсийн нийт улсын /ахлах/ байцаагчдад акт, албан шааадлагын эрх зүйн үндэслэл сургалтын явцад дэд сэдвээр “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалтыг ХШҮХ-тэй хамтран зохион байгуулсан.

3. *Сурталчилгаа, мэдээлэл*: Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын цахим хуудас <http://ub.inspection.gov.mn/index.php/en/>-ын Хууль эрх зүйн буланд Ёс зүйн дүрэм, журам, ёс зүйн хорооны үйл ажиллагааны талаар тогтмол мэдээллэж байна.

4. *Ёс зүйн зөрчлийн талаар*: /Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар мэдээллийн дэлгэрэнгүйг харах/ Тайлант хугацаанд НМХГ-ын ЭМБСХХ-ийн Соёлын хяналтын улсын байцаагч Д.Отгонбаяр, ХНХХХ-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч Ч.Ганчимэг, Баянгол дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын ахлах байцаагч Т.Оюунбилэг, тус хэлтсийн улсын байцаагч Д.Саруул, Баянгол дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Г.Баярсайхан, Дэд бүтцийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Мөнхболд нарын ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдлийг шалгаж, Ёс зүйн хорооны хуралдаанаар хэлэлцэж, тухай бүр дүгнэлт гаргаж, саналаа удирдлагуудад хүргүүлж ажиллаа. Үүнд:

НМХГ-ын ЭМБСХХ-ийн Соёлын хяналтын улсын байцаагч Д.Отгонбаяр нь Богд хааны ордон музейд шалгалт хийж, эрх зүйн үндэслэл муутай, шударга бус шийдвэр гаргасан гэх гомдлыг шалгахад улсын байцаагч нь хуулийн дагуу үндэслэлтэй шийдвэр гаргасан байх тул ёс зүйн зөрчил гаргаагүй гэж дүгнэсэн.

Иргэн Т.Одонтунгалагаас “Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч Ч.Ганчимэг нь ажлын цагаар ресторанд согтуурхаж, хэл амаар доромжлон, гар хүрсэн” гэх агуулга бүхий гомдол гаргасан. Ёс зүйн хорооноос ёс зүйн маргаан үүсгэн шалгаж, ёс зүйн зөрчил гаргасан тул Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн дагуу арга хэмжээ авах, байцаагчийн ёс зүй, төрийн албан хаагчийн нэр хүндийг өндөрт өргөн, аливаа зохисгүй үйлдэл гаргахгүй байх үүргийг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах тухай дүгнэлт гаргаж, НМХГ-ын даргын 2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Б/212 дугаар тушаалаар улсын байцаагч Ч.Ганчимэгт сахилгын шийтгэл ногдуулсан.

Баянгол дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Д.Саруулаас “БГД дэх МХХ-ийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын ахлах байцаагч Т.Оюунбилэг нь хэл амаар доромжилсон, хүмүүстэй ялгаварлан гадуурхаж харьцдаг, хүний амьдралын эмзэг асуудлаар доромжилдог, бүдүүлэг” гэх агуулга бүхий гомдол

гаргасан. Ёс зүйн маргаан үүсгэж, хяналт шалгалтын явцад гомдол гаргагч болон гомдол мэдээлэлд холбогдох талууд ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнэлт гаргасан. Ёс зүйн зөрчил гаргасан Улсын ахлах байцаагч Т.Оюунбилэгт анхааруулах хуудас, улсын байцаагч Д.Саруулд сахилгын шийтгэл ногдуулсан.

АШУҮИС-ийн захирал н.Батбаатараас “улсын ахлах байцаагч Г.Баярсайхан нь албан тушаалаа урвуулан ашиглаж тус сургуульд шалгалт өгөөд тэнцээгүй хүүхдийг сургуульд оруулахыг шаардсан, хэл амаар доромжилсон” гэх агуулга бүхий гомдол гаргасан. Ёс зүйн маргаан үүсгэн шалгаж, зөрчил гаргасан гэж дүгнэсэн. Баянгол дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Г.Баярсайханд сахилгын шийтгэл ногдуулсан.

Дэд бүтцийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Мөнхболд нь иргэнтэй ёс зүйгүй, бүдүүлэг харьцсан гэх утсаар ирсэн гомдлыг хянан шалгаж байх явцад талууд эвлэрч, иргэн өргөдлөө татсан тул ёс зүйн маргаан үүсгээгүй.

Таванбогд ХХК-ийн гаалийн мэргэжилтэн н.Батсүрэнгээс НМХГ-ын Экспорт, импортын хяналтын хэлтсийн улсын байцаагч Д.Оюун нь үйлчлүүж байгаа иргэд, аж ахуйн нэгжээс мөнгө нэхдэг, орж ирсэн бараа таваараас өгөхийг шаарддаг гэх агуулга бүхий гомдол ирсэн. Хяналт шалгалтын явцад гомдол гаргагч иргэн гомдлоо татаж авсан тул ёс зүйн маргаан үүсгээгүй.

Мөн улсын байцаагчийн үнэмлэх, баталгааны тэмдгээ үрэгдүүлсэн 5 улсын байцаагчийн өргөдлийн дагуу Ёс зүйн хороо хуралдаж, дүгнэлт гаргав. Эдгээр албан хаагчид албан үүргээ гүйцэтгэж яваад улсын байцаагчийн үнэмлэхээ хулгайд алдсан, зохих журмын дагуу албан үнэмлэхээ хайсан, хүчингүй болсонд тооцуулсан байх тул Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2015 оны 214 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, хяналт тавих журам”-ийн 2.7 дахь хэсгийг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулахгүй байхаар шийдвэрлэсэн.

5. *Архив, албан хэрэг хөтлөлт:* Ёс зүйн хорооны 2013-2014 оны Ёс зүйн хороог шинэчлэн байгуулах тухай НМХГ-ын даргын тушаал, хурлын тэмдэглэл, ажлын тайлан бүхий 1 боть, ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн дүгнэлт 1 боть, нийт 2 боть материалыг бэлтгэж архивт хүлээлгэн өгсөн.

Боловсруулсан: Ёс зүйн хорооны дарга, НМХГ-ын ХШҮХ-ийн эрх зүйн
ахлах мэргэжилтэн Б.Оюунсүрэн

2015.12.15